

ИННОВАЦЫН САЛБАРЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

Төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэнэ.

ИННОВАЦЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ (2020-2025 ОН)

Тэргүүлэх 5 чиглэлээр 11 технологид хамаарна.

ҮНДЭСНИЙ ИННОВАЦЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний инновацийн шагнал олгоно.

ГАРААНЫ КОМПАНИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Гарааны компани нь 5 жил холбогдох татварын дэмжлэгийг авах ба инновацийн төслийг хэрэгжүүлнэ. Гарааны компани санаачлагч нь Технологи дамжуулах төв эсвэл Хамтын оффист гишүүнээр бүртгүүлсэн байна.

АЛСЫН ХАРАА 2050

Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог хөгжүүлнэ.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Дээд боловсролын сургалтын байгууллага нь эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа эрхэлж, гарсан үр дүнг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

ИННОВАЦЫН ТУХАЙ ХУУЛЬ

“Инноваци” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдлийг хэлнэ.

ИННОВАЦЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ДҮГНЭЛТ ГАРГАХ, МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧДИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нийт шинжээчийн үнэлгээний нийлбэрийн дундаж нь 70 хувь болон түүнээс дээш хувиар үнэлэгдсэн тохиолдолд тухайн инновацийн бүтээгдэхүүнийг шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзнэ.

ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙ

ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Патент олгох, зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах, патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотой үүсэх зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах

ПАТЕНТ ОЛГОХ ЖУРАМ

Патентын мэдүүлгийн бүрдлийн шүүлт, мөн чанарын шүүлт хийж, дүгнэлт гаргах, нийтэд мэдээлэх, патент олгох, улсын бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдох харилцааг зохицуулна.

ОЮУНЫ ӨМЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ, ХӨЛСНИЙ МЭДЭЭЛЭЛ

Оюуны өмчийн газраас үзүүлэх ажил үйлчилгээний үнэ болон улсын бүртгэлийн гэрчилгээ олгохтой холбоотой үнийн мэдээлэл

ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжихтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулна.

БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Барааны тэмдэг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцаа

ПАТЕНТЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ ЖУРАМ

Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг зохион бүтээгч эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд Оюуны өмчийн байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

ОЮУНЫ ӨМЧИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Шилдэг бүтээлд нэр дэвшүүлэх бүтээл нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжил, байгаль орчин, хүний амьдралын чанарт нөлөө үзүүлсэн, экспортын болон дотоодын борлуулалт хийж ашиг олсон, Монгол Улсыг олон улсад сурталчилсан байх шаардлагыг хангасан байна.

ШУТИС-ИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ЭРХ ЗҮЙ (ИННОВАЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ)

